



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 09 сарын 13 өдөр

Дугаар А/27

Улаанбаатар хот

**Байгууллагын ажилчдын нийгмийн
баталгааг хангах хөтөлбөр батлах тухай**

Монгол Улсын Эрүүл Мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.1 дэх заалт, Эрүүл мэндийн яамны төрийн нарийн бичгийн даргын 2019 оны А/66 дугаар тушаалыг ханган ТУШААХ нь:


1. Байгууллагын ажилчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.
2. Байгууллагын ажилчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх, өдөр тутмын түйл ажиллагаандаа мөрдлөгө болгон ажиллахыг ажилчдад үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтийг ханган, мэргэжил арга зүйгээр ханган, үр дүнг тооцож, тайлагнаж ажиллахыг Хүний нөөц, дотоод хяналтын ажилтан (Г.Гантуяа)-д даалгасугай

ДАРГА



Х.ГАНБАТ

Багахангай Эрүүл мэндийн төвийн даргын
2023 оны 09 дугаар сарын 13 -ны өдрийн
127 тушаалын хавсралт



БАГАХАНГАЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН АЖИЛТНЫ НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ХӨТӨЛБӨР

1. ЗОРИЛГО

Ажилчдыг тогтвор суурьшилтай ажиллах, нийгмийн хамгааллыг сайжруулж, тасралтгүй хөгжих боломжийг нэмэгдүүлэх замаар чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэх, сэтгэл ханамжийг нь нэмэгдүүлэхэд ажлыг зохицуулахад хөтөлбөрийн гол зорилго оршино.

2. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРЧИМ

2.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална.

- Хууль дээдлэх
- Ажилтан бүр адил тэгш боломжтой байх
- Төрийн бодлогын баримт бичиг, хууль тогтоомжтой уялдсан байх.
- Ил тод байх, нээлттэй хэрэгжүүлэх
- Эрүүл мэндийн байгууллагын удирдлага, ажилчдын санаачилгад тулгуурлах

3. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТ

3.1 Хөтөлбөрийн зорилгыг дараах зорилтын хүрээнд хэрэгжүүлнэ.

- Ажилтны аюулгүй, эрүүл ахуйн шаардлага хангасан орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлж, эрүүл мэндийг хамгаалах
- Эрүүл мэндийн ажилтны ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх боломжийг сайжруулах
- Санхүүгийн болон санхүүгийн бус урамшууллын шинэ аргыг нэвтрүүлж, эрүүл мэндийн ажилтны бодит орлогыг нэмэгдүүлэх
- Ажилтан бүр хоол унааны зардлыг олгоно.
- Ажилтны нийгмийн хамгааллын чиглэлийн судалгаа, бүртгэл мэдээллийг сайжруулах.
- гэр болон галлагаатай байшинд амьдардаг албан хаагчдад түлээ, нүүрс худалдан авахад байгууллагын зүгээс санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.

4. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

4.1 Ажилтныг орон сууцаар хангах, нөхцөлийг сайжруулах чиглэлээр

- Ажилчдын орон сууцны судалгаа төрөлжүүлэн гаргаж, түүнд үндэслэн орон сууц, хашаа байшин худалдан авах, шинээр барих, нөхцөлийг нь сайжруулахад хууль

тогтоомжийн дагуу банкны урт хугацаатай хөнгөлөлттэй зээлд хамруулах, зохих санхүүгийн болон бусад дэмжлэг туслалцаа үзүүлнэ.

- Ажилчдыг газар өмчилж авахад нь туслалцаа үзүүлнэ.

4.2 Ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх чиглэлээр

- Ажилчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах асуудлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлнэ.

- Ажлын байрны тохижилт, орчин үеийн стандартын жишигт нийцүүлэн тохижуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлж, ая тухтай ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.

- Ажилтныг ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай материаллаг бааз, компьютер, техник хэрэгслээр хангах асуудлыг ажилтнуудаас санал авч судалгаа хийсний үндсэн дээр жил бүрийн төсөвт тусгах замаар шийдвэрлэнэ.

- Ажилтныг ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгохоос гадна мөнгөн бус урамшууллын аливаа аргыг судлан хууль тогтоомжид нийцүүлэн урамшуулна.

- Шинээр гэр бүл болох, эхийн одон болон төрийн засгийн шагналаар шагнуулах зэрэг ажилчдад баярт үйл явдал тохиолдоход нь байгууллагаас эд хөрөнгийн болон мөнгөн тусламж олгоно.

- Хөдөлмөрийн чадвараа алдсан гэр бүлийн гишүүнээ тэтгэх, ажилтны өрхийн орлого буурч нэг гишүүнд ногдох хэмжээ нь амьжиргааны баталгаажих доод түвшинд хүрэхгүй болсон, ар гэрт нь гачигдал тохиолдсон зэрэг нөхцөлд байгууллагаас нэг удаагийн тэтгэмж, туслалцаа олгоно.

- Ар гэрт нь гачигдал гарах, үр хүүхэд, төрсөн ах дүү, хүүхэд нь хуримаа хийх, сургууль төгсөх, диплом, эрдмийн зэрэг хамгаалах зэрэг хүндэтгэн үзэх шалтгаантай тохиолдолд байгууллагаас цалинтай чөлөө олгоно.

4.3 Ажилтныг сургаж, мэргэшүүлэх чиглэлээр

- Ажилтнуудыг жилд 1-ээс доошгүй удаа эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж нарийн мэргэжлийн үзлэг, шинжилгээ хийлгэх, эмчлүүлэх шаардлагатай ажилтнуудыг тухай бүрд нь эмчилгээ, сувилгаа хийлгэх, витаминжуулалтад хамруулах зэрэг эрүүл мэндийг хамгаалахад нь дэмжлэг туслалцаа үзүүлнэ.

- Ажилтнуудаа өвчлөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ажлын байрны эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах, 7 хоногт нэг удаа спорт зааланд тоглуулах зэрэг төрөл бүрийн спортын арга хэмжээнд хамруулж, спорт, биеийн тамирын арга хэмжээг тогтмолжуулна.

- Идэвхтэй хөдөлгөөн, идэвхтэй амралт, явган болон тойрон аяллыг жилд 1-ээс доошгүй удаа зохион байгуулна.

- Нарийн мэргэжлийн эмчийг жилд 2-оос доошгүй удаа урьж ажилчдад яриа, таниулга хийлгэж, эрүүл мэндийн чиглэлийн гарын авлага, материалаар хангана.

4.4 Ажилчдын чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх чиглэлээр

- Баяр ёслол, амралтын өдрүүдийг хамт олноороо тэмдэглэн өнгөрүүлэх, аялал зугаалга зохион байгуулах, урлаг спортын арга хэмжээ зохион байгуулах зэргээр ажиллагсдыг үр бүтээлтэй амрах, алжаалаа тайлах нөхцөл бололцоогоор хангана.

- Ажилтны хүүхдүүдийг зуны амралтаар нь хүүхдийн зусланд хөнгөлөлттэй үнээр амруулах ажлыг зохион байгуулна.

5. ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖИХ ХУГАЦАА

Хөтөлбөрийг 2023-2026 онд хэрэгжүүлнэ.

6. ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН

Ажилчдын ажиллах нөхцөл сайжирч, тогтвор суурьшилтай ажиллах боломж нэмэгдэнэ.

Ажилчдын нийгмийн халамж, дэмжлэг сайжирна.

Хөтөлбөрийн хэрэгжилтийг жил бүрийн 7 дүгээр улиралд тайланг нэгтгэж, тодотгол хийж, нэмэлт өөрчлөлт оруулж болно.